БАТЛАВ.

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА М.БАДАМСҮРЭН

**“ШИНЭ УСАН САН – 9” ТӨСӨЛ**

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Барааны тодорхойлолт: Бараа нь техникийн тодорхойлолтод тусгагдсан үзүүлэлт хүчин чадал шаардлагыг хангасан шинэ бараа бүтээгдэхүүн байна.
2. Стандарт: Монгол улсын болон олон улсын стандартад нийцсэн байна.
3. Баглаа, боодол: Тоног төхөөрөмж нь сав баглаа боодолтой, тээвэрлэлтийн болон хадгалалтын нөхцөл шаардлагыг хангасан байх ба тээвэрлэлт, хадгалалтаас үүссэн гэмтлийг нийлүүлэгч хариуцна.
4. Бараа хүргэх газар: Баянтүмэн сумын Засаг даргын Тамгын газар
5. Ерөнхий шаардлага:

- Ус цэвэршүүлэх иж бүрдэл тоног төхөөрөмж нь Монгол улсын нөхцөлд туршигдсан, үр дүн нь баталгаажсан болон олон улсын стандартын байгууллагын чанар стандартын шаардлага хангасан, орчин үеийн техник, технологийн ололтуудыг шингээсэн байх
- Ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж нь усны найрлага дахь ерөнхий хатуулаг, эрдэсжилт, төмөр, магни зэрэг агууламж ихтэй усыг MNS 900:2018 стандартын шаардлагад нийцүүлэн цэвэршүүлэх, шаардлагатай тохиолдолд халдваргүйжүүлэлт хийх
- Ашиглалтын явцад зардал багатай байх, овор хэмжээ бага байхыг эрмэлзэх
- Ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж нь Монгол орны нөхцөлд ашиглагдах шаардлага хангасан, ашиглалт, эдэлгээний хугацаа 10-аас доошгүй жил байх
- Ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж нь тухайн худгийн усны найрлага, ундрагад тохирох, хэрэглээнд тулгуурласан хүчин чадалтай байх
- Ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны заавар, технологийн заавар, техникийн бичиг баримт нь монгол хэл дээр байна.
- Гүйцэтгэгч ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг суурилуулсны дараах усны химийн ерөнхий шинжилгээ болон суурилуулах ажил гүйцэтгэхэд шаардагдах зардлыг хариуцна.
- Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль, тогтоомж, барилгын норм ба дүрэм, стандарт, техникийн нөхцөлийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Цэвэршүүлэх төхөөрөмж:

| | Шүүлтүүрийн тухай | Д/Д | Төхөөрөмж | Тайлбар | Нэгж | Тоо.ш |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Урьдчилсан шүүлтүүр | 1.1 | Хог баригч | 130 микроноос дээш бохирдолтой хог, хаг, хагшаас, өнгөр, зэв зэргийг шүүнэ. Ашиглалтын турш угааж хэрэглэнэ. Худгийн уст үеийн гүн, статик болон динамик түвшин, насос байрласан түвшин, насосны сорох хоолойн хийцлэлээс хамаарч элс, чулуу гэх мэт механик хольцоос гадна төмрийн зэв, хаг, хагшаас, өнгөр зэргийг шүүх шаардлагатай болдог. Сүлжээний эхэнд байрлаж байгаа тул амархан бохирдож, битүүрснээс ойрхон солих шаардлагатай болдог. Иймээс ашиглалтын турш угааж хэрэглэх, ашиглалтын зардал гарахгүй байх ялтсан шүүлтүүрийг сонгох. Цагт 2.0 м3-ээс доошгүй усыг өнгөрүүлэх хүчин чадалтай байх | ш | 1 |
| 2 | Усан сан | 2.1 | Контактны сан | FRP сан, 2 тн-ы багтаамжтай, эрүүл ахуйн шаардлага хангасан. Хүнсний зориулалтын хуванцар сав байна. 1м х 1м х 1м хэмжээс бүхий нийт 11 ш хавтан байна. | ш | 1 |
| | | 2.2 | Түвшин хэмжигч бүхий механик хаалт | Усан санд ус дүүрэхэд насосыг унтраах, ус багасахад автоматаар ажиллаж эхлэх бололцоог хангана | ком | 1 |
| | | 2.3 | Төмөр суурь | усан сангаас ирэх ачааллыг жигд хуваарилж өгнө. 1м * 2 м хэмжээтэй, двутавраар хийсэн, зэврэлтээс хамгаалсан будагтай | багц | 1 |
| | | 2.4 | Холбох хэрэгсэл | Усанд зэвэрдэггүй ган материал, халиагч, юүлэгч, силикон цавуу, резин жийрэг | ком | 1 |
| | | 2.5 | Усан сангийн агааржуулагч | Усан сангийн ёроолд агаар өгөх тусгай тоноглол бүхий систем | багц | 1 |
| 3 | Насос | 3.1 | Сүлжээний насос | Усан сангаас гарах усанд даралт нэмж өгөх үүрэгтэй. 1 нь нөөцөнд | ш | 2 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Төмөрг үйжүүлэх шүүлтүүр | 4.1 | Баллон | Шүүгүүр бодис агуулах баллон /Wave cyber USA болон түүнтэй дүйцэх/ нь цагт 5.0 м3-ээс доошгүй усыг өнгөрүүлэх хүчин чадалтай байх | ш | 1 |
| | | 4.2 | Удирдлагын хавхлага | Механик болон автомат ажиллагаатай байж болно | ш | 1 |
| | | 4.3 | Төмөргүйжүүлэх шүүлтүүр | Кварцын 2 үе шүүгүүр бодис нь усанд байгалийн амт өгөх үүрэгтэйгээс гадна урьдчилсан шүүлтүүрт баригдаагүй үлдсэн төмрийн ион болон зэв, механик бохирдлыг бууруулах үүрэгтэй байх | кг | 100 |
| | | 4.4 | Дренажийн үе | Кварцийн хайрганы ширхэглэл үйрч бутрахааргүй байх | кг | 15 |
| | | 4.5 | Дренажийн цацраагч хэсэг | Дээд доод цацраагч гол хоолойн хамт иж бүрдлээрээ байх | ком | 1 |
| 5 | Органик бохирдол бууруулагч | 5.1 | Баллон | Шүүгүүр бодис агуулах баллон /Wave cyber USA болон түүнтэй дүйцэхүйц/ нь цагт 5.0 м3-ээс доошгүй усыг өнгөрүүлэх хүчин чадалтай байх | ш | 1 |
| | | 5.2 | Удирдлагын хавхлага | Механик болон автомат ажиллагаатай байж болно | ш | 1 |
| | | 5.3 | Цацраг идэвхит бодис шүүх шүүлтүүр | Идэвхижүүлсэн нүүрсэн шүүлтүүр нь усан дахь эвгүй амт болон үнэр үүсгэгч органик бохирдлыг бууруулахаас гадна усан дахь цацраг идэвхит бодис болох уран, стронци зэргийг бууруулах үүрэгтэй шүүгүүр бодис байх | кг | 70 |
| | | 5.4 | Дренажийн үе | Кварцийн хайрганы ширхэглэл үйрч бутрахааргүй байх | кг | 15 |
| | | 5.5 | Дренажийн цацраагч хэсэг | Дээд доод цацраагч гол хоолойн хамт иж бүрдлээрээ байх | ком | 1 |
| 6 | Зөөлрүүлэгч | 6.1 | Баллон | Шүүгүүр бодис агуулах баллон /Wave cyber USA/ нь цагт 5.0 м3-ээс доошгүй усыг өнгөрүүлэх хүчин чадалтай байх | ш | 1 |
| | | 6.2 | Удирдлагын хавхлага | Механик болон автомат ажиллагаатай байж болно | ш | 1 |
| | | 6.3 | Ион солилцооны давирхай | Зөөлрүүлэх бодис /Ку2/. Усан дахь хатуулгийг бууруулах зориулалттай. | кг | 70 |
| | | 6.4 | Дренажийн үе | Кварцийн хайрга. Шүүгүүр бодисыг тулж, үйлчилгээ, цэвэрлэгээ хийх нөхцөлийг бүрдүүлж өгөх хэмжээнд байх | кг | 15 |
| | | 6.5 | Дренажийн цацраагч хэсэг | Дээд доод цацраагч гол хоолойн хамт иж бүрдлээрээ байх | ком | 1 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 6.6 | Давсны сан дозлогчийн хамт | 500 л-ээс доошгүй багтаамжтай давсны сан, дозлогчийн хамт. Давсны ханасан уусмал уг санд хийгдэж, дозлогчийн тусламжтайгаар зөөлрүүлэгчийн баллон дахь зөөлрүүлэх бодисыг цэнэглэнэ | ш | 1 |
| | | 6.7 | Давс | Давсны санд 100 кг-аас ихгүй давс орох. Суурилуулалт болон үйлчилгээ хийх, бэлэн болгох явцад 50кг нэмнэ, ажиллагаанд хүлээлгэн өгөхөд нэмж 150 кг давсыг хүлээлгэн өгнө. | кг | 300 |
| 7 | Сүүлийн шатны нарийн шүүлтүүр | 7.1 | Механик гэр | Цагт 2.0 м3-ээс доошгүй усыг өнгөрүүлэх хүчин чадалтай байх. Цагийн хамгийн их ачаалалтай үед нэвтрүүлж чадахаар оролт, гаралтын хэмжээ нь 25мм-ээс дээш, доторхи шүүлтүүрийг амархан сольж болдог байх. Гадна гэр, даралт хэмжигч, юүлэгч хаалтын хамт хангана | ш | 1 |
| | | 7.2 | | Итали, полипрополен болон түүнтэй дүйцэхүйц / хэрэглээ болон бохидлоос хамаарч сольж хэрэглэнэ./ 5 микроноос дээш бохирдолтой хог, хаг, хагшаас, өнгөр, зэв зэргийг шүүнэ. Ашиглалтын турш сольж хэрэглэнэ. Усны чанар, хэрэглээнээс хамаарч 3-4 сард солино (3 удаа солих хэрэглээ буюу 1 жилийн турш ашиглах хэрэглээг тооцож 15 ш нь нөөцөнд хангах) | ком | 20 |
| 8 | Усан сан | 8.1 | Ус нөөцлөх зориулалттай | FRP сан, 2 тн-ы багтаамжтай, эрүүл ахуйн шаардлага хангасан. Хүнсний зориулалтын хуванцар сав байна. 1м х 1м х 1м хэмжээс бүхий нийт 10 ш хавтан байна. | ш | 1 |
| | | 8.2 | Түвшин хэмжигч бүхий механик хаалт | Усан санд ус дүүрэхэд насосыг унтраах, ус багасахад автоматаар ажиллаж эхлэх бололцоог хангана | ком | 1 |
| | | 8.3 | Төмөр суурь | Усан сангаас ирэх ачааллыг жигд хуваарилж өгнө. 1м * 2 м хэмжээтэй, двутавраар хийсэн, зэврэлтээс хамгаалсан будагтай | багц | 1 |
| | | 8.4 | Холбох хэрэгсэл | Усанд зэвэрдэггүй ган материал, халиагч, юүлэгч, силикон цавуу, резин жийрэг | ком | 1 |
| | | 8.5 | Усан сангаас гарах уян | Худгийн барилгаас хэрэглэгчдэд зөөврөөр ус өгөхөд зориулсан уян шланг | м | 10 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хоолой | | | |
| 9 | Халдваргүйжүүлэгч | 9.1 | UV Халдваргүй жүүлэгч | Усанд байх бактер болон өвчин үүсгэгч аливаа нян, бактерийг хэт ягаан туяаны гэрлээр шарж устгана. Ламп нь тасралтгүй 9000 цаг ажиллана. | ш | 1 |

Ухаалаг систем

| д/д | Төхөөрөмж | Тоо ширхэг | тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Картаар үйлчлэх ухаалаг систем | 1ком | Иргэд картаар усаа авах зориулалттай ухаалаг систем /сүүлийн үеийнх/ |
| 2 | Интернетийн төхөөрөмж | 1ком | Суманд сүлжээ барьдаг үүрэн холбооны сүлжээтэй байх |

Халаалт

| д/д | Төхөөрөмж | Тоо ширхэг | тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Шалны халаалт | 1ком | 3*4 хэмжээтэй худгийн барилгад суурилуулах / цагийн механизмтай байх/ Нийлүүлэгч компани өөрсдөө угсарч хийж гүйцэтгэх |

**ХЯНАСАН:**

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

ХЭЛТСИЙН ДАРГА /М.НЯМСҮРЭН/

БАЯНТҮМЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА /Э.НАРАНГАРАВ/

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН /С.СОЛОНГО/

**БОЛОВСРУУЛСАН:**

БАЯНТҮМЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ /Э.БАТБАЯР/